



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/23

Өлгий

**Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай**

Усны тухай хуулийн 28.6 заалт, Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны даргын 2022 оны 07 дугаар сарын 01 ний өдрийн 18 дугаар тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Усны тухай хуулийн 28-ийн 6 дахь заалтыг үндэслэн “Дөрвөн бэрх” жуулчны бааз-д ус ашиглан аялал жуулчлал эрхэлж үйл ажиллагаа явуулахад шаардлагатай 4680м<sup>3</sup> усыг нэг жилийн хугацаагаар ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Усны тухай хуулийн 29.1, 18.1.4 дэхь заалтыг үндэслэн “Дөрвөн бэрх” жуулчны баазтай ус ашиглах гэрээ байгуулж ажиллахыг БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Гүлжанд үүрэг болгосугай.

3. Усны тухай хуулийн 30 дугаар зүйл дэхь заалтуудын дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ тайланг дараа оны 1-р улиралд багтаан ирүүлэхийг “Дөрвөн бэрх” жуулчны баазын эзэн иргэн О.Ертайд даалгасугай.

4. Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Толбо сумын байгаль хамгаалагч Х.Сураган-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.МАРАТ